



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Алтай сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2023/88/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар
Утас: 70433061
Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn
Аудитын менежер: А.Цэцэгсүрэн
Утас:70432545
Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn
Хоо өрлөгийн үрс - Аудит ХХК
Аудитор: А.Оюундэлгэр
Утас: 99306289
цахим хаяг: a_oyund@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	13
3.5.3 Нэмэлт төсөв.....	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Залруулсан алдаа.....	15
<i>Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй</i>	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Т.ЦЭЦЭГБАДАМ ТАНАА

2023.02.09 № 02/20
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд сургуулийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮБД-3 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 2022 онд нийт 770 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 736 хүүхэд сургуулийн боловсролд хамруулж биелэлт 95.5 хувьтай байна.

021020078

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 91.2 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. "

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	110,301,020.28	145,560,841.78
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	36,783,998.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	36,783,998.00
3121	Төгрөг	00.00	36,783,998.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	36,783,998.00
33	АВЛАГА	16,404,350.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,404,350.00	00.00
335	Бусад авлага	13,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	13,000,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	93,896,670.28	108,776,843.78
351	Түүхий эд материал	1,040,000.00	490,000.00
35130	Эм боох материал	1,040,000.00	490,000.00
354	Хангамжийн материал	91,916,670.28	108,286,843.78
35410	Бичиг хэргийн материал	4,179,540.00	7,918,540.00
35420	Аж ахуйн материал	54,745,950.28	57,409,700.28
35450	Барилгын засварын материал	3,810,000.00	4,536,000.00
35460	Хүнсний материал	9,164,880.00	18,406,303.50
35470	Бусад хангамжийн материал	20,016,300.00	20,016,300.00
35600	Мал амьтад	940,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,368,993,375.93	5,375,004,791.37
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,368,993,375.93	5,375,004,791.37
392	Биет хөрөнгө	5,348,993,375.93	5,348,704,791.37
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,997,863,488.93	4,997,863,488.93
39202	Хуримтлагдсан элэгдэл	-172,704,245.28	-260,189,980.56
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000.00	23,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,500,000.00	-23,500,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	207,377,257.00	307,169,223.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-175,147,987.00	-178,875,682.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	271,417,271.60	237,354,318.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	-143,198,468.86	-116,768,237.06
39214	Бусад үндсэн хөрөнгө	330,226,768.00	330,226,768.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,870,307.12	-15,062,601.84
39217	Ном	42,029,598.66	46,987,494.66
393	Биет бус хөрөнгө	20,000,000.00	26,300,000.00
39301	Програм хангамж	1,004,000.00	7,304,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,004,000.00	-1,004,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,479,294,396.21	5,520,565,633.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,479,294,396.21	5,520,565,633.15
51	Засгийн газрын хувь оролцоо	5,479,294,396.21	5,520,565,633.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,910,020,624.00	1,910,020,624.00
51101	Өмч: - төрийн	1,910,020,624.00	1,910,020,624.00
512	Хуримтлагдсан үр дүн	2,546,043,005.12	2,589,177,302.06
51210	Өмнөх үеийн үр дүн	2,546,043,005.12	2,547,906,065.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	41,271,236.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,023,230,767.09	1,021,367,707.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,479,294,396.21	5,520,565,633.15

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,216,271,038.00	1,715,043,332.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,279,900.00	73,120,432.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,279,900.00	73,120,432.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	94,279,900.00	73,120,432.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,912,700.00	14,174,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	82,967,200.00	58,946,132.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	161,194,238.00	1,641,922,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,294,254,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,294,254,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	960,796,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,937,857.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,937,857.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	130,153,400.00	347,668,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,153,400.00	347,668,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,234,280,148.08	1,673,772,095.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,234,280,148.08	1,673,772,095.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,183,493,721.08	1,601,083,607.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	762,454,026.00	935,003,984.00
210101	Үндсэн цалин	542,769,450.00	642,940,212.00
210102	Нэмэгдэл	174,162,098.00	252,324,460.00
210104	Урамшуулал	45,522,478.00	39,739,312.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,907,400.00	116,443,723.00
210201	Тэтгэврийн даатгал	72,416,600.00	79,829,251.57
210202	Тэтгэмжийн даатгал	7,622,600.00	9,316,786.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,098,100.00	7,566,888.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,500.00	1,788,496.48
210205	Эрүүл мэндийн даатгал	15,245,600.00	17,942,299.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,735,991.00	296,032,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,913,491.00	10,194,800.00
210302	Түлш, халаалт	106,073,600.00	278,088,900.00
210303	Цэвэр, бохир ус	12,748,900.00	7,748,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,998,986.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,130,100.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	3,529,465.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	525,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	3,701,225.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,113,196.00	00.00
2105	Нормативт зардал	43,815,900.00	71,532,644.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,527,600.00	00.00
210502	Хоол, хүнс	36,542,100.00	71,532,644.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,746,200.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,247,870.00	3,136,900.00

210604	Урсгал засвар	6,247,870.00	3,136,900.00
2107	Томилолт, зочны зардал	255,400.00	00.00
210702	Дотоод албан томилолт	255,400.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,118,500.00	2,414,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,398,500.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	2,414,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	127,959,648.08	176,519,256.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,464,150.00	42,549,106.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	6,635,198.00	12,270,794.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	115,860,300.08	121,699,356.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,786,427.00	72,688,487.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,836,537.00	72,360,019.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,455,000.00	72,360,019.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,278,556.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	668,581.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	668,581.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,281,309.00	328,468.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,281,309.00	328,468.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-18,009,110.08	41,271,236.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-18,009,110.08	41,271,236.94

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,890,020,624.00	5,612,521.00	-384,935,578.08	1,510,697,566.92
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,890,020,624.00	5,612,521.00	-384,935,578.08	1,510,697,566.92
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-7,829,000.80	-7,829,000.80
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624.00	1,023,230,767.09	2,546,043,005.12	5,479,294,396.21
D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624.00	1,023,230,767.09	2,546,043,005.12	5,479,294,396.21
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,863,060.00	1,863,060.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,910,020,624.00	1,023,230,767.09	2,547,906,065.12	5,481,157,456.21
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-1,863,060.00	00.00	-1,863,060.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	41,271,236.94	41,271,236.94
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,910,020,624.00	1,021,367,707.09	2,589,177,302.06	5,520,565,633.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,133,200,857.00	1,656,097,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,312,700.00	14,174,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,312,700.00	14,174,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,312,700.00	14,174,300.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,400,000.00	
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,912,700.00	14,174,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,121,888,157.00	1,641,922,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,294,254,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,294,254,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	960,796,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,937,857.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,937,857.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	130,153,400.00	347,668,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	130,153,400.00	347,668,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,133,200,857.00	1,619,313,202.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,133,200,857.00	1,619,313,202.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,079,113,061.00	1,542,006,947.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	762,276,800.00	935,003,984.00
210101	Үндсэн цалин	542,592,224.00	642,940,212.00
210102	Нэмэгдэл	174,162,098.00	252,324,460.00
210104	Урамшуулал	45,522,478.00	39,739,312.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	102,907,400.00	116,443,723.00
210201	Тэтгэврийн даатгал	72,416,600.00	79,829,251.57
210202	Тэтгэмжийн даатгал	7,622,600.00	9,316,786.25
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,098,100.00	7,566,888.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,500.00	1,788,496.48
210205	Эрүүл мэндийн даатгал	15,245,600.00	17,942,299.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,735,991.00	296,032,600.00
210301	Гэрэл, цахилгаан	4,913,491.00	10,194,800.00
210302	Түлш, халаалт	106,073,600.00	278,088,900.00
210303	Цэвэр, бохир ус	12,748,900.00	7,748,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,579,224.00	00.00
210401	Бичиг хэрэг	965,867.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,562,465.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	525,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	3,990,458.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,259,434.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,276,000.00	00.00
2105	Нормативт зардал	40,985,496.00	76,156,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	625,600.00	00.00

210502	Хоол, хүнс	38,591,530.00	76,156,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,768,366.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,600,100.00	3,136,100.00
210604	Урсгал засвар	4,600,100.00	3,136,100.00
2107	Томилолт, зочны зардал	255,400.00	00.00
210702	Дотоод албан томилолт	255,400.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,720,000.00	9,526,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	9,526,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,052,650.00	105,707,740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,795,050.00	91,390,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,257,600.00	14,317,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,087,796.00	77,306,255.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	46,733,556.00	76,977,787.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,455,000.00	76,977,787.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,278,556.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,072,931.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,072,931.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,281,309.00	328,468.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,281,309.00	328,468.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	36,783,998.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	36,783,998.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	36,783,998.00

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,656,077,250.00	1,618,984,734.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,656,077,250.00	1,618,984,734.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,578,303,550.00	1,542,006,947.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	966,904,800.00	935,003,984.00
210101	Үндсэн цалин	739,307,400.00	642,940,212.00
210102	Нэмэгдэл	214,688,500.00	252,324,460.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00
210104	Урамшуулал	12,908,900.00	39,739,312.00
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,757,800.00	116,443,723.00
210201	Тэтгэврийн даатгал	82,186,900.00	79,829,251.57
210202	Тэтгэмжийн даатгал	9,582,600.00	9,316,786.25

210203	ҮОМШӨ-ний даатгал	7,716,600.00	7,566,888.98
210204	Ажилгүйдлийн даатгал	1,933,700.00	1,788,496.48
210205	Эрүүл мэндийн даатгал	19,338,000.00	17,942,299.72
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	296,032,600.00	296,032,600.00
210301	Гэрэл, цахилгаан	10,194,800.00	10,194,800.00
210302	Түлш, халаалт	278,088,900.00	278,088,900.00
210303	Цэвэр, бохир ус	7,748,900.00	7,748,900.00
2105	Нормативт зардал	76,156,300.00	76,156,300.00
210502	Хоол, хүнс	76,156,300.00	76,156,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,136,100.00	3,136,100.00
210604	Урсгал засвар	3,136,100.00	3,136,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,544,700.00	9,526,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,544,700.00	9,526,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	105771250.00	105707740.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,454,250.00	91,390,740.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	14,317,000.00	14,317,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77773700.00	76977787.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	77,773,700.00	76,977,787.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	77,773,700.00	76,977,787.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,656,077,250.00	1,656,097,200.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,294,254,500.00	1,294,254,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,294,254,500.00	1,294,254,500.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	347,668,400.00	347,668,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	347,668,400.00	347,668,400.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	14,154,350.00	14,174,300.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14154350	14174300
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	36,783,998.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	65	65
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	41	41
620003	Үйлчлэх ажилтан	23	23

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтай сумын сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд Хүүхдийн хөгжлийг дэмжих, суралцахад тулгарч буй бэрхшээлийг арилгах, амжилттай суралцахад бүх талын хамтын ажиллагаа, оролцоог хангаж, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилготойгоор 65 ажилтан албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулсан байна.

Танхимаар тасралтгүй 33-34 долоо хоног хичээллэж, сургуульд суурилсан үнэлгээ улсын хэмжээнд анх удаа хийгдэж 4 багшийн заасан хичээл I-III түвшинд үнэлэгдэж сарын 10%-25% урамшуулал авсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 онд баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41.2 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансдын үлдэгдэлд өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	36,784.0	36,784.0
Авлага	16,404.3	-	-16,404.3
Бараа материал	93896.7	108,776.8	14,880.1
Үндсэн хөрөнгө	5,368,993.4	5,375,004.8	6,011.4
Нийт хөрөнгө	5,479,294.4	5,520,565.6	41,271.2
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,479,294.4	5,520,565.6	41,271.2
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,479,294.4	5,520,565.6	41,271.2

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 36.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Авлагын эхний үлдэгдэл 16.4 сая төгрөг байсан нь тайлант хугацаанд бүрэн барагдсан байна.
- ✓ "Техно Зон", "Ай ти зон", "ЕСМ ХХК" "Багшийн туслах" зэрэг компаниудаас 57.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамжийн худалдан авалтыг хийж, НББ-д тусгасан байна. Мөн Сумын ИТХ 2022 оны 09 сарын 26 ны өдрийн 7/08 тоот тогтоолын дагуу 8.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 42.6 сая төгрөгийн тавилга эд хогшил тус бүрийг актлаж бүртгэлээс хассан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1173.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 368.0 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5.6 сая төгрөг, зарлагыг 1547.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсролын салбар нь үр дүн гүйцэтгэлд суурилсан төсвөөр төсвөө боловсруулснаар нийт зардлыг 91.6 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Тайлант оны батлагдсан төсвийг 200.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,294.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 347.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 14.2 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,294.2 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 347.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 14.2 сая төгрөг, нийт 1,656.1 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 0.3 сая төгрөгийг төвлөрүүлэн, 36.8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,618.0 сая төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 36.2 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 0.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
				Зөрүү	Биелэлт
80226	Байр ажиглалтын үйлчилгээ	3.8	3.8	0	100%
80111	Барилгын тогтмол зардал	299.2	299.2	0	100%
80113	Нийтлэг үйлчилгээ	48.5	48.2	0.3	99.4%
80312	Сургалт семинар	1.9	1.9	0	100%
81605	Эрүүл мэндийг дэмжих	4.4	4.4	0	100%
81801	Үдийн цай хөтөлбөр	77.7	76.9	0.8	99%
81806	Дотуур байрны үйлчилгээ	108.9	108.4	0.5	99.5%
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	50.9	50.9	0	100%
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	8.6	8.5	0.1	98.8%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	941.6	908.0	33.6	96.4%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	96.3	94.7	1.6	98.3%
81844	Гүнзгийрүүлсэн болон сургалтын орчныг сайжруулах	8.0	8.0	0	100%
83602	ЗГ болон ЗД-ын нөөц хөрөнгөөс хуваарилсан	3.6	3.6	0	100%
83603	Нэмэлт дээд шатнаас хуваарилсан төсөв	2.6	2.6	0	100%
	дүн	1,656.1	1,619.0	37.1	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Ховд аймгийн Алтай сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хоо өрлөгийн үрс аудит ХХК-ны аудитор А.Оюундэлгэр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Алтай сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1216,7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 24,3 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1715,0 сая төгрөгөөр 2 хувиар буюу 34,3 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 27,4 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагын төсвөөс зардал зарцуулаагүй.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээ 119 мэдээнээс 4 мэдээ хугацаа хоцруулж 115 мэдээг хугацаанд бүрэн мэдээлсэн, хуулийн хэрэгжилт 95.7.0 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 1.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авч 10.7 сая төгрөгийн 4 зөвлөмж өгч, шийдвэрийн нийт биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага					
Зөвлөмж	4	10.7	4	10.7	100.0
Нийт дүн					

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Алтай сумын сургуулийн 2022 оны халаалтын зардлын төсөв 278,1 сая төгрөг гүйцэтгэлээр нэхэмжлэх 298,8 сая төгрөг болж 278,1 сая төгрөгийг төлж 20,8 сая төгрөгийг төлж чадаагүй өрөнд тусгаагүй байна. Дараагийн аудитаар төлөвлөлт, хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,5 сая төгрөгийн алдаа¹, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг зөрчсөн 1.7 сая төгрөгийн гүйлгээг аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

5.1 Төлбөрийн акт

5.2 Албан шаардлага

5.3 ЗөвлөмжТөсвийн хуультай холбоотой

Илрүүлэлт: Захирлын 2022.06.17-нй А/25 тоот тушаалаар шагналд 0,7сая төгрөг 9.26-ны өдрийн Б/62 тоот тушаалаар 1.3 сая төгрөг шагнал урамшуулал, 2022.01.25 А/01 тоот тушаалаар ахмадуудад хүдэтгэл үзүүлэх 0.5 сая төгрөг нийт 2,5 сая төгрөг зарцуулсан нь "Төсвийн тухай хуулийн 16.5.5 заасан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалттай нийцэхгүй байна.


Өгсөн зөвлөмж: Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/ сая төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
Хуультай холбоотой: төсвийг зориулалтын дагуу зарцуулах	1	2.5			1	2.5					1	2.5
Дүн	1	2.5			1	2.5					1	2.5

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  А.ОЮУНДЭЛГЭР

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.